



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 6/40

Хэрлэн сум

Засаг даргыг огцруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 64.2, 64.3 64.4, 64.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Галшар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 7 дугаар сарын 04-ний 01 дүгээр тогтоолоор сумын Засаг дарга Ө.Сарантуяагийн 2022 оны хагас жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг хэлэлцээд хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонх буюу 63 хувь хангалтгүй гэж дүгнэж, нэр бүхий 12 төлөөлөгч Засаг даргыг огцруулах санал ирүүлсэн тул хүлээн авч огцруулсугай.

2. Засаг даргыг шинээр томилох хүртэлх хугацаанд түүний бүрэн эрхийг Засаг даргын орлогч (Д. Шижирбаяр)-д хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

3. Сумын Засаг дарга Ө.Сарантуяатай хуулийн дагуу тооцоо хийхийг Галшар сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ш. Цэвэлсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010883